



## АЛТНЫ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДАЛ

### АЛТНЫ САЛБАР 2018: ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН 2018 ОНЫ ТАЙЛАН ДАХЬ АЛТ ОЛБОРЛОГЧ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

#### ТАНИЛЦУУЛГА

Олборлох Үйлдвэрлэлийн Ил тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-ын тайланд үндэслэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дийлэнх хувийг эзэлдэг алтны салбарын эдийн засгийн өгөөжийн талаар нийтэд ойлгомжтой тойм мэдээлэл бий болгох зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

ОУИТБС нь ашигт малтмал, газрын тос, байгалийн хий зэрэг байгалийн баялгаас орж буй орлого, түүний зарцуулалтыг олон нийтэд ил тод болгох замаар түүнийг иргэдийн сайн сайхан, тогтвортой хөгжлийн төлөө үр ашигтай зарцуулахад төр, хувийн хэвшлийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн олон улсын санаачилга юм. Уг санаачилгыг энгийнээр тайлбарлавал, нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд улс, орон нутгийн төсөвт төлсөн бүх татвар, төлбөр, хураамж, хандив тусламжаа тайлагнаж, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниас хүлээн авсан бүх орлогоо тайлагнаж, ийнхүү хоёр талаас ирүүлсэн тайланг хараат бус, хөндлөнгийн аудитын байгууллага тулган

баталгаажуулж, зөрүүг шалган олон нийтэд ил тод болгох үйл явц юм.

Энэхүү судалгаанд ОУИТБС-ын хүрээнд Засгийн газраас гаргасан 2018 оны санхүүгийн жилийн мэдээлэл бүхий тайланг үндсэн эх сурвалж болгон, баримтын шинжилгээний аргуудыг ашиглав. Засгийн газар болон компаниудын ирүүлсэн тайланг тулган баталгаажуулдаг ОУИТБС-ын Нэгтгэл тайланд нийт 202 компани хамрагдсаны ердөө 43 нь алтны олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байв. Мөн Засгийн газрын тайлан болон тулган баталгаажуулалт хийгдсэн нэгтгэл хоёрын зөрүү ихээхэн бага байсан тул алтны салбарын компаниудыг бүрэн хамрах зорилгоор зөвхөн Засгийн газрын тайланг гол болгон авлаа. Энэ хүрээнд алтны ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 365 компаниас улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хураамжуудын мэдээлэлд анализ хийлээ. Ашигт малтмал, газрын тосны газраас (АМГТГ) 2019 онд гаргасан салбарын тойм мэдээллийг мөн ашиглав.

Тайлангийн эхний хэсэг салбарын нийт тусгай зөвшөөрөл, лиценз эзэмшигчид, тэдгээрийн ОУИТБС-ын тайланд хамрагдсан байдал, алтны шороон болон үндсэн ордуудын батлагдсан нөөц, үйлдвэрлэл, Монгол банканд тушаасан алтны хэмжээ зэрэг ерөнхий мэдээллийг агуулна. Алтны компаниудаас улсын төсөвт төвлөрүүлсэн

нийт орлого, тэдгээрийн төрлүүд, топ болон татвар төлөөгүй компаниудын мэдээллийг хоёрдугаар хэсэгт багтаав. Гурав дахь хэсэгт орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээлэл, хандив тусламж, байгаль орчны нөхөн сэргээлт, ажлын байр зэрэг бусад нэмэлт мэдээллийг орууллаа.


## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### АЛТНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЭЗЭМШИГЧИД

2018 оны эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээнд ашигт малтмалын 1,676 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчинтэй байсны 34 хувь буюу 575 нь алтны тусгай зөвшөөрөл байжээ.<sup>1</sup> Энэ үзүүлэлтэд дан алт болон зарим дагалдах метал агуулсан ордын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг оруулж буй бөгөөд зэс гэх мэт бусад ордод алт нь дагалдах эрдэс байдлаар олборлож буй цөөн тооны тусгай зөвшөөрлийг оруулаагүй болно.


Алтны тусгай зөвшөөрлүүд нийт 328.4 мянган га газар нутгийг хамарч байгаа нь нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн хамрах талбайн 20 хувийг эзэлж байна.

График 1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо (ашигт малтмалын төрлөөр)



<sup>1</sup> 2019 оны байдлаар АМГТГ-аас гаргасан мэдээлэлд 552 тусгай зөвшөөрөл, 335 аж ахуйн нэгж гэсэн байгаа боловч үүнийг 2018 оны эцсээс хойш өөрчлөгдсөн байдал гэж үзэн ЗГ-аас гаргасан ОУИТБС-ын тайлангийн мэдээллийг гол болгов.

График 2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн эзлэх талбай (га)



- Алтны лицензийн талбай 328.4га
- Бусад ашиглалтын лицензийн талбай 1,292.3га

Байршлаар нь авч үзвэл, Төв аймгийн нутагт хамгийн олон буюу 160, Хөвсгөл аймгийн нутагт хамгийн цөөн буюу 1 тусгай зөвшөөрөл олгогджээ. Харин Орхон, Говьсүмбэр аймагт алтны тусгай зөвшөөрөл бүртгэгдээгүй байна. Энэ тооцоонд 2-3 аймгийн нутаг дамнасан тусгай зөвшөөрлийг давхардуулан тоолсон болно.

Эдгээр тусгай зөвшөөрлийг давхардаагүй тоогоор нийт 365 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагаас хамгийн олон нь Гацуурт ХХК 15, Уулс заамар ХХК 8, Монголросцветмет нэгдэл 7, Сентерра гоулд, Алтандорнод Монгол, Тод-Ундрага компаниуд тус бүр 6 тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

АМГТГ-ын бүрэн бус мэдээлэлд үндэслэн алтны ашиглалтын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийн тоог харьцуулж харвал, 2006 оноос эхлэн буурах хандлагатай явсаар 2010 онд хамгийн бага хэмжээндээ хүрч, 2011 оноос буцаж нэмэгдсээр 2015 онд дээд

хэмжээндээ хүрсэн нь салбарын татварын орчин, түүнээс хамааралтай Монгол банканд тушаасан алтны хэмжээтэй шууд хамааралтай байна. Энэ талаар энэ бүлгийн төгсгөл хэсэгт тайлбарлав.

График 3. Алтны тусгай зөвшөөрлийн тоо (он, оноор)




График 4. Аймгуудын нутаг дэвсгэр дэх алтны тусгай зөвшөөрөл (давхардсан тоогоор)





График 5. Алтны хамгийн олон тусгай зөвшөөрөл эзэмшигч 10 компани




### ОУИТБС-ЫН 2018 ОНЫ ТАЙЛАНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Алтны тусгай зөвшөөрөл эзэмшигч 365 компанийн 188 буюу 51.5 хувь нь 2018 оны ОУИТБС-ын тайлангаа цахим системээр дамжуулан ирүүлжээ. Эдгээрийн 46 нь нэгтгэл

тайланд хамрагдаж, тулган баталгаажуулалт хийгдсэн нь нэгтгэл тайланд хамрагдсан нийт 200 компанийн 23 хувь болж байна.

График 6. Алтны тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ОУИТБС 2018-д хамрагдсан байдал



### ОРДУУДЫН НӨӨЦ, ҮЙЛДВЭРЛЭЛ

Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн цаана Оюутолгойн ордын алтны нөөцийг оруулахгүйгээр (1118 тн) ойролцоогоор 527 тонн алтны нөөц бүртгэгдсэний 89 хувь нь

үндсэн ордод хамаарна. Харин нийт ордын 80 хувийг эзэлдэг шороон ордууд тогтоогдсон нөөцийн 11 хувийг бүрдүүлдэг байна.

Хүснэгт 1. Алтны ордуудын нөөц (ордын төрлөөр)

Ордын ангилал	Нөөц (тонн)	Тусгай зөвшөөрлийн тоонд эзлэх хувь (%)	Алтны нөөц (%)
Үндсэн орд	469.1	20	89
Шороон орд	57.7	80	11
Нийт	526.8	100	100


1991 онд Монгол Улсад үйлдвэрлэж Төв банканд худалдсан алтны хэмжээ 0.8 тн байсан бол Алт хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр жил бүр өсөж 2001 онд 13.8 тн хүрч байжээ. Энэ хэмжээ 2003 он хүртэл аажим буурч, 11.1 тн хүрээд 2005 онд 15.2 тн болж нэмэгдсэн нь алтны үнийн өөрчлөлттэй холбоотой гэж албаны эх сурвалж тайлбарлаж байна. Учир нь энэ хугацаанд алтны салбарын татварын орчинд томоохон өөрчлөлт гараагүй.

Харин алтны үнэ дэлхийн зах зээл дээр өсөлттэй байсан 2006-2012 онд Монгол банканд тушаасан алтны хэмжээ жил бүр бгассаар 2010 онд 2.1 тн болж хамгийн бага хэмжээндээ хүрчээ. Үүний үндсэн шалтгаан нь 2006 онд батлагдсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай буюу алт, зэсийн үнийн өсөлтөд 68 хүртэл хувийн

өсөн нэмэгдэх татвар ногдуулах тухай хууль гэж үзэж болохоор байна. Улмаар 2011 онд 68 хувийн гэнэтийн өсөлтийн татварыг хүчингүй болгох хууль хэрэгжиж эхэлсэн, мөн 2014 онд Монгол банканд тушаасан нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2.5 хувь болгон бууруулсан зэрэг бодлогын өөрчлөлтийн үр дүнд алт үйлдвэрлэл нэмэгдэж, Монгол банканд худалдсан хэмжээ 2018 онд 22 тоннд хүрсэн байна.

2016 оноос эхлэн Монгол банканд иргэдийн худалдсан алтны хэмжээ аж ахуйн нэгж байгууллагынхаас давсан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид лицензийн талбайгаа түрээсээр ашиглуулж, хувь хүн дээр бүртгэл хийж эхэлсэнтэй холбоотой. Мөн алтны хууль бус наймаа, контрабандын нөлөө гэж үзэх нь бий.

График 7. Монгол банканд худалдсан алтны хэмжээ (кг)



## МОНГОЛ БАНКНЫ ХУДАЛДАН АВАЛТЫН ТАЛААР

Эдийн засгийн хувьд алт нь хөрөнгийн үнэ цэнийг хадгалах хэрэгсэл гэдэг утгаараа эрт дээр үеэс төлбөр тооцоонд ашиглагдсаар ирсэн төдийгүй аливаа улсын Төв банкнаас гүйлгээнд гаргаж буй бэлэн мөнгө алтаар баталгаажсан байх тухай “алтан стандарт” 20

дугаар зууны дунд үе хүртэл хэрэгжсэн байдаг. Өнөөдөр дэлхий дээр “алтан стандарт”-ыг мөрдөж буй улс байхгүй хэдий ч Төв банкнууд валютын нөөцийнхөө тодорхой хувийг алт хэлбэрээр хадгалах явдал түгээмэл байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд санхүүгийн зах

зээлд тогтворгүй байдал давамгайлж, зээл болон хөрөнгө оруулалтын эрсдэл өндөр байгаатай холбоотойгоор алт нөөцлөх нь эрсдэл бага, бусад валютын эсрэг тогтвортой хамгаалалт болно гэж үзэх явдал түгээмэл болсон.

Монгол Улсын хувьд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай” хуультай холбоотойгоор алтны экспортын хууль бус үйл ажиллагаа өргөжсөний эсрэг хариу үйлдэл болгож дотоод олборлосон алтыг зөвхөн Монгол банк буюу түүнээс эрх авсан арилжааны банканд худалдан, төв банкаар дамжуулж экспортлох зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр (2014) хийсэн.

Тиймээс өнөөдөр Монгол банк нь байгууллага, иргэдээс алт худалдан авч, гадаадад цэвэршүүлэх, экспортлох үйл ажиллагааг эрхэлдэг цорын ганц эрх бүхий

байгууллага болсон. Ингэснээр дараах ач холбогдолтой гэж тус банкнаас тайлбарлаж байна. Үүнд:

Алт тушаалт нэмэгдсэнээр 1) төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 2) улс орны богино хугацаат гадаад зээлийн төлбөрийг төлөх чадварыг хангах, 3) Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн гадаад валютын баталгааг хангах, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, 4) улс орныг бүхэлд нь хамарсан дотоод болон гадаад хүчин зүйлийн улмаас үүссэн эдийн засгийн хямралт байдлаас хамгаалах гэжээ. Хэдий тийм боловч эдгээр үр ашиг нь валютын нөөц нэмэгдүүлэхтэй холбоотой болохоос алттай шууд холбогдон гарах үр өгөөж гэж үзэхэд өрөөсгөл болно. Алтны худалдаа, цэвэршүүлэлт, экспортыг тусгай зөвшөөрөл бүхий бизнесийн байгууллагууд эрхлэх нь олон улсын практик юм.

## АЛТНЫ САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

### НИЙТ ТАТВАР, ТӨЛБӨР, ТЭДГЭЭРИЙН БҮТЭЦ

Засгийн газрын тайлагнасан дүнгээр алтны салбар 2018 онд Улсын төсөвт 67.2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн нь тухайн онд нийт уул уурхайн салбараас төвлөрүүлсэн орлогын 4 хувь болж байна.

Улсын төсөвт төлдөг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Ашигт малтмалын

нөөц ашигласны төлбөр, Ажил олгогчоос төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр гэсэн 4 төрлийн орлогын урсгал алтны салбараас төвлөрүүлсэн нийт орлогын 68 хувийг эзэлж байна.

### Хүснэгт 2. Улсын төсөвт алтны салбараас төвлөрүүлсэн орлого, 2018


Орлогын төрөл	Бүрдүүлсэн орлого (сая төг)	Эзлэх хувь (%)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	14,842.32	22
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	12,435.49	19
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын НД, ЭМД-ын шимтгэл	11,634.21	17
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	6,988.03	10
Нэмэгдсэн өртгийн албан татвар (Гааль)	4,571.87	7
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	3,761.57	6

Гаалийн албан татвар	2,204.71	3
Ус ашигласны төлбөр	1,358.35	2.1
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	814.95	1.3
Нэмэгдсэн өртгийн албан татвар (ТЕГ-т төлсөн)	738.39	1.1
Газрын төлбөр	504.51	1
Нөхөн төлбөр	252.72	0.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	246.48	0.4
Торгууль	215.81	0.3
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	214.30	0.3
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	160.26	0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	41.40	0
Ус бохирдуулсны төлбөр	35.21	0
Агаарын бохирдлын төлбөр	8.47	0
Гаалийн үйлчилгээний хураамж	5.19	0
Бусад	6,144.10	9
НИЙТ (орон нутгийн төсөв ороогүй)	67,178.32	100

Тус салбарын төсөвт төвлөрүүлдэг орлогын хэмжээ сүүлийн 20 жилд хамгийн өндөр нь 2013 онд 151 тэрбум төгрөг байсан бол

хамгийн багадаа 2015 онд 32.8 тэрбум төгрөг болж байжээ. Энэ хэмжээ 2016 оноос хойш байнга өсөх хандлагатай байна.

График 8. Алтны салбараас улс, орон нутгийн төсөвт төлсөн орлого, оноор (тэрбум төг.)



### БУСАД ОЛБОРЛОХ САЛБАРТАЙ ХАРЬЦУУЛСАН ДҮН

2018 оны байдлаар алтны салбарт уул уурхайн салбарын нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 34.5 хувь ногддог хэдий ч тус салбараас нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлогын 4 хувийг бүрдүүлж байгаагаас нэг тусгай зөвшөөрөлд ногдох төсвийн орлогоороо олборлох салбар дундаас

хамгийн бага үр ашигтай нь харагдаж байна. Тухайлбал, зэсийн ашиглалтын нэг тусгай зөвшөөрөлд ногдох улс болон орон нутгийн төсвийн орлого 27.5 тэрбум төгрөг, нүүрс 2.9 тэрбум төгрөг байгаа бол алтны хувьд 140 сая төгрөг болж байна.


### Хүснэгт 3. Уул уурхайн салбарын төсвийн орлого, ашигт малтмалын төрлүүдээр<sup>2</sup>

Ашигт малтмалын төрөл	Төсөвт төлсөн орлого		Нэг тусгай зөвшөөрөлд ногдох орлого (тэрбум төг)
	Тэрбум төгрөг	Эзлэх хувь (%)	
Алт	82	4.0	0.14
Нүүрс	910.6	44.3	2.89
Жонш	16.3	0.8	0.09
Төмөр	17.1	0.8	0.22
Зэс, молибден	871.9	42.5	27.56
Бусад	155.7	7.6	0.32
Нийт	2,053.6	100.0	1.23

2018 оны улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 10,062.5 тэрбум төгрөг байснаас 2,053.6 тэрбум нь уул уурхайн

салбараас орсон гэж албаны эх сурвалжууд мэдээлжээ. Эндээс үзвэл алтны салбар нийт төсвийн орлогын 0.8 хувийг бүрдүүлж байна.

График 9. Гол ашигт малтмалуудын тусгай зөвшөөрлийн тоо болон төсвийн орлогод эзлэх хувь



### КОМПАНИЙН ТҮВШНИЙ МЭДЭЭЛЭЛ

2018 оны Засгийн газрын ОУИТБС-ын тайлангаар алтны тусгай зөвшөөрөл эзэмшигч 235 компаниас улс, орон нутгийн төсөвт орлого хүлээж авсан нь нийт 365 компанийн 64 хувь болж байна. Үлдэх 36 хувь нь төсөвт орлого оруулаагүй гэж үзэж болох юм.

Нийт 210 компани ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр төлснөөс ердөө 59 компани ашигт малтмалын нөөц ашигласны

төлбөр төлжээ. Энэ нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн нийт компанийн дөнгөж дөрөвний нэг нь олборлолтын үйл ажиллагаа явуулж байна уу, эсвэл компаниуд нөөц ашигласны төлбөр төлөхгүйгээр олборлолт явуулсаар байна уу гэдэг асуулт үүсгэж байна. Мөн алтны тусгай зөвшөөрөлтэй компаниуд орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нэлээд дүнгээр


<sup>2</sup> ОУИТБС 2018 тайлан болон УУЯ-ны мэдээллийг нэгтгэн тооцоолсон



төлсөн байгаа тухай дараагийн бүлэгт тодорхой дурдав. Энэ байдлаас алтны тусгай зөвшөөрөлтэй зарим компани АМНАТ зохих ёсоор төлөхгүйгээр орон нутагт, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр төлөөд нинжа хэлбэрээр ажилладаг гэсэн зарим мэдээлэл үндэслэлтэй байж болохоор харагдаж байна.

Түүнчлэн, алтны тусгай зөвшөөрөл эзэмшигч 365 компанийн 210 нь тусгай зөвшөөрлийн төлбөрөө төлсөн гэж Засгийн газар тайлагнасан байх тул бусад нь уг төлбөрөө төлөөгүй буюу тусгай зөвшөөрлөө цуцлуулах хэмжээний зөрчилтэй гэж үзэхэд хүргэж байна.

График 10. Алтны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төсөвт оруулсан орлого



Улс, орон нутгийн төсөвт ямар нэг хэмжээгээр орлого оруулсан 235 компаниас 1 тэрбум төгрөгөөс дээш орлого оруулсан доорх 15 компанид алтны салбарын төсвийн нийт орлогын 79 хувь ногдож байна. Харин 100 сая төгрөгөөс дээш орлого оруулсан нийт 59 компани орлогын 96 хувийг бүрдүүлжээ.

Алтны 1 тусгай зөвшөөрөлтэй МАК, 7 тусгай зөвшөөрөлтэй Монросцветмет компаниуд төсөвт томоохон хэмжээний орлого оруулдаг ч тэдний үйл ажиллагаанд алтны олборлолт бага хувь эзэлдэг буюу төсөл тус бүрээр ялгаж харах боломжгүй тул доорх хүснэгтэд оруулаагүй болно.

Мөн алтыг дагалдах өөр ашигт малтмалын хамт олборлодог, эсвэл алтны олборлолтын зэрэгцээ хайгуулын өөр төслүүд хэрэгжүүлдэг компаниудын татвар, төлбөрийн мэдээлэл нэгдсэн дүнгээрээ орсон болно. Цаашид илүү нарийн салгаж харахын тулд төсөл тус бүрээр тайлагнах шаардлагатай юм.

Хүснэгт 4. Төсөвт 1 тэрбум төгрөгөөс дээш орлого оруулсан алтны компаниуд

Компанийн нэр	Нийт төлбөр
Уулс заамар	19,595,643,480
Баян айраг эксплорэйшн <sup>3</sup>	10,633,283,870
Сентеррагоулд монголия	7,035,720,597
Монполимет	5,110,021,022
Монгол майнинг энд эксплорэйшн	2,836,381,383
Улз гол	2,620,513,416
Тэн Хун	2,445,336,238
ОНТРЭ	2,393,076,117
Мондулаан трейд	2,311,057,469
Гацуурт	2,175,949,803
Эко алтан заамар	2,135,413,300
Заамар гоулд	1,788,050,211
Степ голд	1,354,996,109
ГБНБ	1,348,381,988
Тод-Ундрага	1,219,954,276
Про Аурум	951,845,748

<sup>3</sup> Алт, мөнгөний ордын олборлолтын зэрэгцээ ээсийн хайгуулын төсөл хэрэгжүүлдэг бөгөөд дээрх дүнд компанийн нийт татвар, төлбөр орсон ба энэ нь ижил төстэй бусад компанид мөн адил юм.

## АЛТНЫ САЛБАР БА ОРОН НУТАГ

### ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2018 онд алтны тусгай зөвшөөрөл эзэмшигч 83 компаниас орон нутгийн төсөвт 14.9 тэрбум төгрөгийн орлого хүлээж авсан гэж Засгийн газар тайлагнажээ. Орон нутгийн төсөвт орж буй орлого нийт 12 төрлийн татвар, төлбөр, хураамж зэргээс бүрддэг хэдий ч 36 хувь буюу 5.3 тэрбум төгрөг нь түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр орсон байгаа нь алтны олборлолтын үйл ажиллагаатай шууд

холбоогүй, харин тухайн компанийн нэмэлт үйл ажиллагаа байж болох юм. Эсвэл алтны зарим компаниуд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ашигт малтмалын тухай хуульд заасан хэмжээгээр төлөхийн оронд орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр төлөөд тусгай зөвшөөрлийн талбайдаа нинжа хэлбэрээр хувь хүмүүс оруулж олборлолт явуулдаг байж болзошгүй гэсэн хардлага бий.

#### Хүснэгт 5. Орон нутагт төсөвт төвлөрүүлсэн орлого (төрлөөр)

Орлогын төрөл	Дүн (сая төг)	Эзлэх хувь (%)
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр <sup>4</sup>	5,342.5	35.9
Ус ашигласны төлбөр	1,655.6	11.1
Газрын төлбөр	594.5	4.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	248.4	1.7
Нөхөн төлбөр	242.7	1.6
Торгууль	108.4	0.7
Авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	41.7	0.3
Ус бохирдуулсны төлбөр	35.2	0.2
Гадаад мэргэжилтэн ажилтны ажлын байрны төлбөр	30.4	0.2
Байгаль хамгаалах зардлын 50%-ийг дансанд төвлөрүүлсэн дүн	16.9	0.1
Бусад <sup>5</sup>	6,583.6	44.2
<b>НИЙТ</b>	<b>14,899.9</b>	<b>100.0</b>

### ХАНДИВ ТУСЛАМЖ

Орон нутгийн төсөвт алтны компаниудаас хүлээн авсан орлогын 44 хувь буюу 6.5 тэрбум төгрөг (хүснэгт 7-г харна уу) нь бусад гэсэн ангилалд байгаа нь анхаарал татаж байна. ОУИТБС-ын тайлангийн маягт, зааварт энэ хэсэг нь сайн дураар тайлагнах хандив, тусламжаас өөр гэж заасан боловч компаниуд болон Засгийн газар орон нутгийн төрийн байгууллагад хүлээн авсан хандив тусламжийг голчлон энэ хэсэгт тайлагнажээ.

Иймд доорх хүснэгтэд харуулсан орон нутагт хамгийн их орлого оруулсан компаниудын

жагсаалт нь тэдгээрээс нутгийн захиргааны байгууллагуудад олгосон хандив, дэмжлэгийн хэмжээг давхар агуулсан гэж үзэж болно. Эдгээр 17 компани нь алтны салбараас орон нутагт төлсөн орлого, дэмжлэгийн 94 хувийг бүрдүүлж байна.

Түүнчлэн нутгийн захиргааны байгууллагын хүлээн авсан хандивын нийт дүн 6.2 тэрбумаар үнэлэгдэж буй боловч үүний 2 тэрбум орчим нь мөнгөн бус буюу бараа, ажил үйлчилгээ хэлбэрээр олгогджээ.

<sup>4</sup> Алтны олборлолтын үндсэн үйл ажиллагаатай шууд холбогдохгүй.

<sup>5</sup> Орон нутгийн төсөвт төлсөн бусад татвар, хураамж, төлбөр байх ёстой боловч ихэвчлэн хандив, тусламжтай давхардаж байна.

## Хүснэгт 6. Орон нутагт 100 сая төгрөгөөс дээш дүнгээр орлого төвлөрүүлсэн компаниуд

Компани	Орон нутагт төлсөн дүн
Уулс заамар	5,984,409,800
Эко алтан заамар	2,135,413,300
Баян айраг эксплорэйшн	1,377,907,576
Монгол майнинг энд эксплорэйшн	770,403,200
Улз гол	667,213,700
Тэн Хун	541,413,083
Заамар гоулд	459,640,400
Монполимет	450,362,713
ГБНБ	374,260,800

Компани	Орон нутагт төлсөн дүн
Сентеррагоулд монголия	307,732,809
Мондулаан трейд	236,159,580
Буд-Ундрам	164,908,474
Рэдулкан	128,502,900
Тэргүүн майнинг	124,436,992
БМНС	116,207,793
Эрдэнэдорно	114,448,002
Ай Би Би Ай	101,554,100
НИЙТ	14,054,975,221

## НӨХӨН СЭРГЭЭЛТ

2018 онд алтны 52 компани байгаль орчны нөхөн сэргээлтийн тайлангаа ОУИТБС-д ирүүлсэн нь бүрэн дүр зураг гаргахад хангалтгүй байв. Иймд энэ хэсгийн мэдээллийг АМГТГ-аас 2019 онд гаргасан алтны салбарын мэдээллээс дэлгэрүүлэн авч орууллаа.

Тухайн онд алт олборлолтын үйл ажиллагаанд 12 аймгийн 31 сумын 681.7 га газар өртөж эвдэрсэн бол 809.7 га газарт нөхөн сэргээлт хийгджээ. Энэ ажилд компаниуд нийт 2.7 тэрбум төгрөг зарцуулсан хэмээн тайлагнажээ.

## АЖЛЫН БАЙР

АМГТГ-ын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэст ирүүлсэн тайлангаар 2018 онд нийт 84 аж ахуйн нэгж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж 6,910 хүнийг ажлын байраар хангажээ. Үүнээс

## Хүснэгт 7. Алт олборлолтод өртсөн болон нөхөн сэргээлт хийгдсэн талбай

№	Үзүүлэлт	2018 онд
1	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай /га/	809.74
2	Уулын ажилд хамрагдсан талбай /га/	681.77
3	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	696.77
4	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай /га/	650.36
5	Байгаль орчин хамгаалах зардал /сая.төг/	1247.82
6	Нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал /сая.төг/	2731.87

алтны шороон ордод 5,897, үндсэн ордод 971, алтны үүсмэл ордод 42 ажилтан тус тус ажилласан мэдээлэл байна. Нийт ажилтны 20 хувь нь орон нутгаас, 14 хувь нь инженер техникийн ажилчид (ИТА) байв.

## Хүснэгт 8. Алтны салбарт ажиллагсдын тоо

№	Ордын төрөл	Нийт ажиллагсад	Эмэгтэйчүүд эзлэх хувь (%)	ИТА	Оператор	Туслах	Орон нутгаас ажиллагсад
1	Алт (шороо)	5897	9.73	777	2510	1567	952
2	Алт (үндсэн)	971	9.37	169	189	188	403
3	Алт (үүсмэл)	42	14.3	9	28	5	2
	Нийт	6910		955	2727	1760	1357

## ДҮГНЭЛТ

Доорх тоо баримтаас харахад алтны салбар нь тусгай зөвшөөрлийн тоо болон хамрах газар нутгийн хэмжээтэй нь харьцуулбал хамгийн үр ашиг багатай уул уурхайн салбар гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

- 2018 оны эцсийн байдлаар алтны ашиглалтын 575 тусгай зөвшөөрлийг 365 компани эзэмшиж байгаа нь уул уурхайн салбарын нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 34.5 хувь, тэдгээрийн хамрах газар нутгийн 20 хувийг эзэлж байна.
- Ийнхүү нийт хүчин төгөлдөр ашиглалтын тусгай зөвшөөрлийн 34 хувийг дангаараа бүрдүүлдэг алтны салбар нь 2018 онд улсын төсөвт 67.2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн нь тухайн онд уул уурхайн салбараас төвлөрүүлсэн нийт орлогын 4 хувь, төсвийн нийт орлогын дөнгөж 0.8 хувийг эзэлж байв.
- 2018 онд Засгийн газар алтны тусгай зөвшөөрөл эзэмшигч 235 компаниас улс, орон нутгийн төсөвт орлого хүлээж авснаа тайлагнасан нь алтны тусгай зөвшөөрөлтэй компаниудын 64 хувь болж байна. Үүнээс ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг зөвхөн 210 компани төлснөөс ердөө 59 нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, алтны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын 42.5 хувь нь тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй буюу тусгай зөвшөөрлийг нь цуцлах нөхцөл бүрдсэн, 83.8 хувь нь олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй, эсхүл нөөц ашигласны төлбөрөө зохих ёсоор төлөөгүй үзэж болохоор байна.
- Улс, орон нутгийн төсөвт ямар нэг хэмжээгээр орлого оруулсан алтны компаниудаас 1 тэрбум төгрөгөөс дээш орлого оруулсан 15 компанид салбарын төсвийн нийт орлогын 79 хувь, 100 сая төгрөгөөс дээш орлого оруулсан 59 компанид 96 хувь нь ногдож байна. Иймд үлдэх 306 компани улс, орон нутгийн төсөвт маш бага хувь нэмэртэй нь харагдлаа.
- Алтны салбар нь нэг тусгай зөвшөөрөлд ногдох төсвийн орлогоороо олборлох салбар дундаас хамгийн бага үр ашигтай харагдаж байна. Тухайлбал, алтны ашиглалтын нэг тусгай зөвшөөрөлд оногдох улс болон орон нутгийн төсвийн орлого 140 сая төгрөг байгаа бол зэсийн хувьд 27.5 тэрбум төгрөг, нүүрснийх 2.9 тэрбум төгрөгт хүрчээ.
- Мөн 2018 онд алтны тусгай зөвшөөрөл эзэмшигч 83 компаниас орон нутгийн төсөвт 14.9 тэрбум төгрөгийн орлого хүлээж авчээ. Гэхдээ үүний 36 хувь нь түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр орсон байгаа нь компаниудын алтны олборлолтын үйл ажиллагаатай шууд холбоогүй нэмэлт үйл ажиллагаа, эсхүл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулалт орон нутагт гажуудсантай холбоотой байж болохоор байна.
- Нийт 575 тусгай зөвшөөрлийг 365 компани эзэмшиж буйгаас 51 хувь нь 2018 оны ОУИТБС-ын тайлангаа цахим системээр дамжуулан ирүүлсэн нь хангалтгүй буюу алтны компаниуд ил тод байдлыг хангах үйл явцад идэвхтэй оролцохгүй байгааг харуулж байна.
- Алтны салбарын эдийн засгийн үр ашгийг бодитойгоор үнэлэхэд зайлшгүй харгалзан үзэх байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийг бууруулах, арилгахад шаардагдах зардлын албан ёсны бүртгэл, тоо баримт, тооцоо судалгаа байхгүй болохыг энд мөн дурдах нь зүйтэй.